

ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМАЛ:

CITES нь анх 1973 онд гарын үсэг зурсан хотын нэрээр нэрлэгдсэн “Вашингтоны конвенц” буюу англиар “Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora” монголоор “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци” юм.

1975 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон эдүгээ 152 улс конвенцид нэгдэн орсон орсон байна.

Уг конвенцийн зорилго нь сав шим ертөнцийн чухал бүрдэл хэсэг болсон зэрлэг амьтан, ургамлын аль нэгэн зүйл олон улсын худалдаанд хэт их хэмжээгээр ашиглагдаж, устгах аюулд орохоос хамгаалах явдал төдийгүй уг конвенци тухайн зүйлийг хамгаалахын зэрэгцээ олон улсын хяналт зохицуулалттай худалдах явдал юм.

Уг конвенци нь 3 хавсралттай:

Нэгдүгээр хавралтад олон улсын худалдаа нь тухайн зүйлийн оршин тогтноход нөлөө үзүүлж байгаа, эсвэл нөлөө үзүүлж болох, устгах аюулд орсон бүх зүйл хамаарна.

Хоёрдугаар хавсралтад эдүгээ устгах аюулд ороогүй ч тухайн зүйлийн цаашид оршин тогтноход харшлахаар ашглалт явуулахгүй байх үүднээс олон улсын худалдааг хяналт зохицуулалттай явуулахгүй бол устгах аюулд орж болзошгүй зүйлүүд багтдаг.

Гуравдугаар хавсралтад аль нэг тал өөрийн улсын нутаг дэвсгэрийн дотор зохицуулах шаардлагатай гэж тодорхойлсон ба тэдгээрийг худалдаалах явдлыг хянахад бусад талуудтай хамтран ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа зүйлүүд багтана.

Монгол улс тус конвенцид нэгдэн орох тухай хуулийг 1995 оны 5-р сарын 4-ны өдөр батлаг гаргасан бөгөөд манай улс 1996.04.04-ний өдрөөс нэгдэн орсноор 133 дахь гишүүн орон болсон.

Монгол улсаас энэ конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад 14 зүйл хөхтөн, 71 зүйл шувуу, 8 зүйл ургамал, 2 зүйл загас, шавьж, мөлхөгч, тус бүр нэг зүйл орсон юм.

Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг зохицуулах үүрэгтэй Удирдан зохицуулах зөвлөл, Шинжлэх ухааны зөвлөлийг Конвенцийн 9-р зүйлийн 1.6 заалтын дагуу байгуулан ажиллаж байна.

**УРГАМЛЫН ҮР, ҮРСЛЭГ, СУУЛГАЦ, АМЬТАН, ТҮҮНИЙ ҮР, ХӨВРӨЛ ҮР,
ТҮҮХИЙ МАХ, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН БИЧИЛ БИЕТНИЙ
ӨСГӨВӨР, ЭМГЭГТ МАТЕРИАЛЫН ДЭЭЖИЙГ УЛСЫН ХИЛЭЭР
НЭВТРҮҮЛЭХ БООМТУУДЫН ЖАГСААЛТ**

Нэг. Ургамлын үр, үрслэг, суулгац нэвтрүүлэх хилийн боомтууд:


1. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
2. Дорноговь аймгийн Замын-Үүд;
3. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар;
4. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
5. Увс аймгийн Боршоо;
6. Дорнод аймгийн Эрээнцав;
7. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
8. Ховд аймгийн Булган.

/Энэ хэсэгт ЗГ-ын 2010 оны 22 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./

Хоёр. Мал, амьтан нэвтрүүлэх болон үржлийн мал импортод боомтууд:

1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
2. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар;
3. Дорноговь аймгийн Замын-Үүд;
4. Дорнод аймгийн Хавирга;
5. Дорнод аймгийн Эрээнцав;
6. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
7. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
8. Хөвсгөл аймгийн Ханх;
9. Завхан аймгийн Арцсуурь;
10. Увс аймгийн Боршоо;
11. Дорнод аймгийн Ульхан;
12. Ховд аймгийн Булган.

/Энэ хэсэгт ЗГ-ын 2010 оны 22 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./



Гурав. Мал, амьтны үр, хөврөл үр, бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг нэвтрүүлэх болон үржлийн мал экспортлох хилийн боомтууд:

1. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
2. Дорноговь аймгийн Замын-Үүд;
3. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
4. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт.

Дөрөв. Түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох боомтууд:

1. Увс аймгийн Боршоо боомт;
2. Завхан аймгийн Арцсуурь;
3. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар;
4. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
5. Дорнод аймгийн Эрээнцав;
6. Дорнод аймгийн Ульхан;
7. Дорнод аймгийн Хавирга;
8. Дорноговь аймгийн Замын-Үүд;
9. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
10. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
11. Баян-Өлгий аймгийн Өлгий;
12. Хөвсгөл аймгийн Ханх;
13. Ховд аймгийн Булган.

/Энэ хэсэгт ЗГ-ын 2010 оны 22 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./

Тав. Түүхий мах, дайвар бүтээгдэхүүн импортлох боомтууд:

1. Дорноговь аймгийн Замын-Үүд;
2. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар;
3. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
4. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
5. Баян-Өлгий аймгийн Өлгий;
6. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
7. Дорнод аймгийн Эрээнцав.